

МУНН-ын Улс Төрийн Ерөнхий Зөвлөлийн
2016 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн
хурлаар батлав

**МОНГОЛЫН УЛАМЖЛАЛЫН НЭГДСЭН НАМЫН
УИХ-ЫН 2016 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Нэг. Улс төрийн хүрээнд

**“Хан төрийн сайнд харц ард жаргаму, харц ардын хүчинд хан төр тогтму”
сургаалыг төрийн албанд төлөвшүүлж, төрийн албан тушаалд байгуулсан
гавъяагаар нь томилдог үндэсний уламжлалыг сэргээнэ.**

- 1.1. Монгол хүн Монгол газар шороондоо эзэн байх үзлийг төрийн бодлогын тулгуур үндэс болгон Үндэсний эрх ашгийг дээдлэх зарчмыг Монголын төрд төлөвшүүлнэ.
- 1.2. Монгол төрийн түүхэн уламжлалыг үндэс болгон эзэнгүй төрийг эзэнтэй болгоно.
- 1.3. Монгол хүний үнэ цэнэ, үнэлэмжийг хөсөрдүүлж буй алдааг залруулан хүнийг эн тэргүүнд өргөн тавих бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.4. Язгуур эрх ашгаа дээдэлдэг үндэсний үзэлтэй иргэдээр төрийн албыг бэхжүүлэн, төрийн албан тушаалд яс үндэс, шашин шүтлэг, намын харъяаллыг үл харгалзан ажиллуулах зарчмыг тууштай хэрэгжүүлж, Монгол Улсад улс төрийн шинэчлэлийг нэн даруй хийнэ.
- 1.5. Засаг захиргааны нэгжийг нэгтгэн томсгож, Монгол Улсыг 3 бүс болгон бүсчилж хөгжүүлэх хуулийн төсөл санаачлан өргөн барина.
- 1.6 Монгол Улсын “Улс төрийн намын тухай” хууль, “Сонгуулийн хууль”-ийг боловсронгуй болгож, иргэд, сонгогчдын нийтлэг эрх ашгийг хамгаалсан зохицуулалт хийнэ.
- 1.7. Хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх засаглалын үйл ажиллагааны харилцан хамааралыг үгүй болгож хууль ёсыг чанд сахих, шударга ёсыг хэлбэрэлтгүй мөрдөх зарчмыг тууштай хэрэгжүүлэн эрх зүйт төрийг бүрдүүлнэ.
- 1.8. Монгол Улсын хөгжил дэвшил нь Монгол үндэстний нийтлэг эрх ашиг гэж үзэж гадаад дахь элэг нэгт Монгол ахан дүүстэйгээ харилцах харилцааг шинэ түвшинд гаргаж, тэдний Монголд ирж Монгол хүний ёсоор ажиллаж, амьдрах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- 1.9. Авилгал, хээл хахуулийн сүлжээг таслан зогсоож, түүнд холбогдсон албан тушаалтнуудад хуулийн хатуу хариуцлага хүлээлгэдэг эрх зүйн орчин бүрдүүлж “Хулгайч шоронд байх ёстой” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.10. Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөг жинхэнэ утгаар хэрэгжүүлж, дөрөв дэх засаглал тунхаглалаас бодит хүчин зүйл болгон төлөвшүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН

УХА0122

№ 781

2016 он 04 сар

000009

Хоёр. Гадаад бодлого, Үндэсний аюулгүй байдлын хүрээнд

“Дээдийг засахад доордоос, гадаадыг засахад дотоодоос эхлэх” Инжинаашийн сургаалыг мөрдлөг болгоно

- 2.1. Монгол Улсын тусгаар тогтнолын баталгааг Монгол Улсын газар нутгийн бүрэн бүтэн байдал, түүн дээр амьдрах Монгол үндэстний хүн амын өсөлт гэж үзнэ.
- 2.2. Үндэсний Аюулгүй Байдлын яам байгуулж үндэсний язгуур эрх ашгийг зөрчсөн аливаа илрэлтэй хатуу тэмцэнэ.
- 2.3. Монгол Улсын Зэвсэгт хүчний шинэчлэлийг бүх талаар хэрэгжүүлж, улс орноо батлан хамгаалах номлол, төрийн цэргийн бодлогыг боловсронгуй болгоно.
- 2.4. Хоёр хөрштэйгээ харилцах харилцааг гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болгоно.
- 2.5. Гадаад бодлогын хүрээнд бусад улс орнуудтай тогтоосон уламжлалт найрсаг харилцааг хөгжүүлэн өргөжүүлж, шинэ түвшинд гаргана.
- 2.6. Улсын хил хамгаалалтыг чанарын өндөр түвшинд гаргана.

Гурав. Эдийн засгийн хүрээнд

Эзэн Чингэс хааны “Орлогын ихээр баяждаггүй зарлагын багаар баяждаг” гэсэн сургаалыг тулгуур болгоно.

- 3.1. Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагаанд эзэн зочны харилцааг тэнцвэртэй байлгах бодлого баримтлана.
- 3.2. Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг нөхөн сэргээгдэх баялаг дээр суурилсан байх ёстой гэж үзнэ.
- 3.3. Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг мал аж ахуй, газар тариалан, боловсрол, эрүүл мэнд, аялал жуулчлал, банк санхүү үйлчилгээний салбарт чиглүүлэн түүний дэд бүтцийг тухайн жилийн төсвийн хөрөнгө оруулалт болон хандивлагчдын зээл тусламжаар тэргүүн ээлжинд дэмжинэ.
- 3.4. Бүс, орон нутагт жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх зорилгоор ээлтэй татварын эрх зүйн орчинг бий болгож, аялал жуулчлал, боловсрол, эрүүл мэнд, банк санхүү болон үйлчилгээний салбарыг бүх талаар хөхүүлэн дэмжих цогц бодлого авч хэрэгжүүлнэ.
- 3.5. Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх чиглэлд хамгийн сүүлийн үеийн өндөр технологи ноу хауг нэвтрүүлж буй хувь хүн, аж ахуйн нэгж, албан байгууллагыг төрөөс хөхүүлэн дэмжинэ. Ойрын 20 жилд Монгол Улс дэлхийн зах зээлд экологийн цэвэр хүнс нийлүүлэгч гол улс болох зорилт тавин ажиллана.
- 3.6. Гааль, татварын бодлогыг Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн хөшүүрэг болгох чиглэлийг баримтлан энэ талын эрх зүйн орчинг өөрчилнэ.
- 3.7. Эдийн засаг, бизнесийн салбарт төрийн оролцоог багасгаж, төрөөс бизнест үзүүлж буй дарамт шахалтыг үгүй болгох чиг баримтална.
- 3.8. Стратегийн ач холбогдолтой эдийн засгийн салбаруудыг төрийн мэдэлд байлгана.
- 3.9. Газар болон газрын хэвлийн баялгийг зөвхөн Монгол хүнээр дамжиж эзэмших, ашиглах эрх зүйн орчинг бий болгоно.

3.10. Жижиг дунд үйлдвэр, аж ахуйн нэгжийг тусгай бодлогоор хөхүүлэн дэмжинэ. Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, экспорт орлох үйлдвэрлэлийг эхний ээлжинд төрийн бодлогоор дэмжих таатай орчин бүрдүүлнэ.

Дөрөв. Нийгмийн хүрээнд

“Амьддаа бие биеэ хайрла” О.Дашбалбарын захиас...

МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТ

УХА0122

№ 7
16 он 04 сар

- 4.1. Хүн ардынхаа амьдралын чанарыг эрс дээшлүүлэх нь төрөөс нийгмийн өмнө хүлээх үндсэн үүрэг гэж үзнэ.
- 4.2. Монголын төрөөс Монгол хүн амын өсөлтөд онцгой анхаарал хандуулж тусгай бодлого гарган хэрэгжүүлнэ.
- 4.3. Улс орон, ард түмнийхээ төлөө өөрсдийн оюун санаа, хүч хөдөлмөрийг зориулсан ахмадуудаа дээдлэн хүндлэж, халамжлахыг төр ба иргэдийн эрхэм үүрэг болгоно.
- 4.3. Залуучуудын гэр бүл болох, орон сууц худалдан авах, бизнес эрхлэх, сурч боловсроход нийгмийн бодлогыг чиглүүлж ажиллана.
- 4.4. Хил хязгаар нутагт алба хааж буй болон амьдран сууж буй иргэдийн нийгмийн асуудлыг төрийн онцгой анхааралд авч цогц бодлого хэрэгжүүлэх хууль санаачлана.
- 4.5. Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалыг хувь хүнээс сонголттойгоор төлөх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- 4.6. Төрийн эрүүгийн ялын бодлогыг эрс өөрчлөж хүний эрхийг дээдэлсэн, хүмүүнлэг, энэрэнгүй болгоно.

Тав. Боловсрол, соёл, шинжлэх ухааны хүрээнд

“Хүнийг сургахгүй болбоос ёсыг мэдэхгүй” Данзанравжаагийн сургаалыг үндэс болгон

- 5.1. Анхан болон дунд шатны сургалтын боловсролын системд Монгол хүнийг бий болгох концепцийг шинээр бий болгож улмаар Монгол хүнд дээд боловсрол олгодог тогтолцооны эрх зүйн орчинг хуульчилж бүрдүүлнэ.
- 5.2. Шинжлэх ухааныг хөгжлийн хөтөч хэмээн үзэж, оюуны амжилт, нээлт бүрийг хөхүүлэн дэмжих бодлого баримтлана. Төрийн бодлогыг боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарыг сэргээн хөгжүүлэхэд чиглүүлнэ.
- 5.3. Бүх шатны боловсролын тогтолцоог орчин үеийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн мэргэшсэн ажилтан бэлтгэх, тэднийг үйлдвэрлэлтэй холбоход гол анхаарлаа хандуулж ажиллана.

000011

**Зургаа. Байгаль орчны хүрээнд
Цэвэр онгон байгалиа хойч үедээ өвлүүлэн үлдээнэ**

6.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэлхийн шим мандлын олон улсын тусгай бүс байх чиг бодлогыг баримтлан олон улсын дэмжлэг авах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулна.

6.2. Монгол орны онгон сайхан байгальг хамгаалах, зүй зохистой ашиглах хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. Байгал орчинд сөрөг нөлөө үзүүлэх бүх үйлдлийг таслан зогсооно.

6.3. Хүний зохисгүй харьцаанаас болж байгальд учруулсан хор хохирлыг багасгах, байгальд нөхөн сэргээлт хийх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр үр дүнтэй зохион байгуулна.

6.4. Монгол оронд нүүрлээд байгаа цөлжилтийг зогсоох талаар эрдэм шинжилгээний болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.

6.5. Монгол Улсыг байгаль орчинд хамгийн ээлтэй дэлхийн орон болгож, хүн ам нь эрүүл, аюулгүй орчинд аж төрөх нөхцлийг бүрдүүлнэ.

**Мөнх тэнгэрийн хүчин ивээж
Монгол мөнх оршиг**



СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНД

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2016. 04. 27 № 781

танай _____-ны № _____-т

Нийцлийн талаарх дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа Монголын Уламжлалын Нэгдсэн намын "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-т Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хянаж дүгнэлт гаргав.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Сонгуулийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг Төрийн аудитын байгууллагад ирүүлж Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах хариуцлага хүлээнэ.

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд намын боловсруулсан сонгуулийн мөрийн хөтөлбөр Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх үүрэгтэй.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар УИХ-ын ээлжит сонгуульд оролцох Монголын Уламжлалын Нэгдсэн намаас ирүүлсэн "Сонгуулийн мөрийн хөтөлбөр"-ийг Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт-4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг удирдлага болгон Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн дүгнэлт гаргав.

Дүгнэлт

Монголын Уламжлалын Нэгдсэн намын Сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуультай нийцсэн болно.

Хувийг: Монголын Уламжлалын Нэгдсэн намд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

\\10.10.10.20\Bichig_Khureg\Yawsan_Bichig\2016\0425\NAG96.Docx

073795

000013